БАТЛАВ.
"ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨҮГ-ЫН
ЗАХИРАЛ Я.НЯМЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТ
ТТ35356 ☏ 5790719

# ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | | Хариуцах албан тушаалтан |
|---|---|---|---|---|
| | | Хугацаа | Хүрэх үр дүн | |
| | **Нэг. Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:** | | | |
| 1.1 | 2022 онд ХАСХОМ гаргах үүрэг бүхий албан тушаалтнуудын нэрсийн жагсаалтыг гаргаж салбарын дээд ЭБАТ /ТӨБЗГ-ын/-д хүргүүлэх, | 2022 оны 01 дүгээр сарын 05-ны дотор | Салбарын дээд ЭБАТ хянагдаж АТГ-т 1-р сарын 10-ны дотор хүргэгдсэн байна. | ХНГЭЗХ /ЭБАТ/ |
| 1.2 | Шинэчлэн гаргах ХАСХОМ-ийг цаг хугацаанд нь баталгаажуулах | 2022 оны 02 дугаар сарын 15-ны дотор | Авилгын эсрэг хуулийн 11 дүгээр зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийг хэрэгжүүлсэн байна. | ХНГЭЗХ /ЭБАТ/ |
| 1.3 | ХАСХОМ-ийн тайлан мэдээг зохих журмын дагуу гаргаж ТӨБЗГ-т хүргүүлэх; | 2022 оны 2 дугаар сарын 25-ны дотор | Албан тушаалтны ХАСХОМ бүртгэх, хадгалах, ЭБАТ-ны үйл ажиллагааны журмын 4.2 дахь заалтыг хэрэгжүүлсэн байна. | ХНГЭЗХ /ЭБАТ/ |
| 1.4 | АТГ-аас хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянахдаа давхар ажил эрхлэлтийн талаар өгсөн хязгаарлалтыг хэрэгжүүлэх, хяналт тавих; | Тухай бүр | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн | ХНГЭЗХ /Хэлтсийн дарга, ЭБАТ/ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | дагуу үйл ажиллагаа явуулсан байна. | |
| 1.5 | 2022 онд шинээр албан тушаалд томилогдох албан тушаалтан, ажилтнуудын болон их хэмжээний өөрчлөлттэй холбоотойгоор ХАСХОМ-ийг 30 хоногийн дотор гаргуулж ажиллах; | Тухай бүр | Авилгын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн дагуу үйл ажиллагаа явуулсан байна. | ХНГЭЗХ /ЭБАТ/ |
| 1.6 | Хяналт шалгалт хийх, гэрээ байгуулах, тендерийн үнэлгээний хороонд ажиллах ажилтнуудаас ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл тайлбарыг гаргуулах, хяналт тавих, АТГ-ын цахим системд бүртгэх, зохих арга хэмжээг авч ажиллах; | Тухай бүр | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу үйл ажиллагаа явуулсан байна. | ХНГЭЗХ /Хэлтсийн дарга, Хууль, эрх зүйн мэргэжилтэн, ЭБАТ/ САAX /Эдийн засагч, Худалдан авах ажиллагааны мэргэжилтэн/ |
| 1.7 | Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, холбогдох арга хэмжээг авч ажиллах; | Тухай бүр | Өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шалгах, шалгалтын үр дүн сайжирсан байна. | ХНГЭЗХ /Хэлтсийн дарга, Хууль, эрх зүйн мэргэжилтэн/ |
| | **Хоёр. Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах чиглэлээр:** | | | |
| 2.1 | Байгууллагын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг цахим хуудсанд байршуулах; | Жилдээ | Байгууууллагын үйл ажиллагааны зардал болон өмнөх оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт олон нийтэд ил тод болсон байна. | САAX /Хэлтсийн дарга, Эдийн засагч/ |
| 2.2 | Байгууллагын 2022 оны ажлын тайлан, гүйцэтгэлийг Эрчим хүчний яаманд тайлагнах, аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг нийтлэх; | Жилдээ | Байгууллагын 2022 оны ажлын тайлан, гүйцэтгэл нь салбарын удирдах дээд байгууллагад танилцуулагдсан байна. | САAX /Хэлтсийн дарга/ |
| 2.3 | Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх, шилэн дансны цахим хуудсанд худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллүүд, тайлан, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга | Жилдээ | Хуулийн хэрэгжилт хангагдаж, байгууллагын санхүү, хөрөнгө оруулалт, худалдан авалтын талаарх мэдээлэл ил тод болсон | САAX /Эдийн засагч/ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, орон тооны өөрчлөлт, аудитын тайлан, дүгнэлт зэрэг шаардлагатай мэдээллүүдийг цаг тухайд нь байршуулах: | | байна. | |
| 2.4 | Төвийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах тендер зарлан явуулах, шалгаруулах ажиллагааг ил тод, нээлттэй хэрэгжүүлэх; | Тухай бүр | Бараа, ажил үйлчилгээ худалдан авах арга хэмжээ хуулийн дагуу, чанартай хэрэгжиж, мэдээлэл олон нийтэд хүртээмжтэй болно. | СААХ /Худалдан авах ажиллагааны мэргэжилтэн/ |
| | **Гурав. Мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр:** | | | |
| 3.1 | Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг төвийн цахим хуудсанд байршуулах; | Тухай бүр | Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх дүрэм, журам нийтэд нээлттэй ойлгомжтой байна. | ХНГЭЗХ /Хууль эрх зүйн мэргэжилтэн, Мэдээлэл технологи, дотоод сүлжээ хариуцсан мэргэжилтэн/ |
| 3.2 | Төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, зарцуулалтын байдалд дүн шинжилгээ хийж, хариуцлагыг дээшлүүлэх; | Улирал бүр | Санхүүгийн хариуцлагыг дээшлүүлэх арга замыг тодорхойлж, хэрэгжүүлсэн байна. | СААХ /Хэлтсийн дарга/ ДАХШХ /Хэлтсийн дарга/ |
| 3.3 | Гадаадын зээл тусламж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт болон төсөл, хөтөлбөр, арга хэмжээ бүрийн явц, гүйцэтгэлийг цахимаар хянах орчныг бүрдүүлж, нээлттэй, ил тод болгох, мэдээллийг сайжруулах; | Улирал бүр | Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн явц, гүйцэтгэлийг цахимаар хянах боломжийг судалж, хэрэгжүүлсэн байх | ЗТХХ /Хэлтсийн дарга/ |
| 3.4 | Захиалагч техник хяналт болон зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагааны талаар мэдээллийн сан бүрдүүлэх; | Улирал бүр | Мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласан байна. | Ерөнхий инженер бөгөөд дэд захирал /ЗТХХ, ЗТМХ/ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3.5 | Салбарын инженер техникийн ажилтны сургалтын хуваарь, хөтөлбөр, мэргэжлийн комиссын шийдвэр мэдээллийг байгууллагын цахим хуудсанд тухай бүрт нь байршуулах; | Улирал бүр | Мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласан байна. | СҮЦ /Эрхлэгч, Мэдээлэл технологи, дотоод сүлжээ хариуцсан мэргэжилтэн / |
| 3.6 | Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээллэх; | Тухай бүр | Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангасан байна. | ХНГЭЗХ /Хууль, эрх зүйн мэргэжилтэн, Мэдээлэл технологи, дотоод сүлжээ хариуцсан мэргэжилтэн/ |
| 3.7 | Дотоод аудитын тогтолцоог боловсронгуй болгох | Улирал бүр | Холбогдох журмын хэрэгжилтийг хангасан байна. | ДАХШХ /Хэлтсийн дарга/ |
| | **Дөрөв. Байгууллагын ажилтан, албан хаагчид, иргэдийг соён гэгээрүүлэх чиглэлээр:** | | | |
| 4.1 | Иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч хуульд заасан хугацаанд шийдвэрлэх; | Жилдээ | Иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байна. | ХНГЭЗХ /Хууль, эрх зүйн мэргэжилтэн, холбогдох хэлтэс, нэгж/ |
| 4.2 | АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ /фб, твиттер, ютүб суваг/, лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг хэлбэрээр олон нийтэд хүргэх; | Жилдээ | Авлигын эсрэг хууль тогтооомжийг иргэдэд сурталчилж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлсэн байна. | ХНГЭЗХ /ЭБАТ, Мэдээлэл технологи, дотоод сүлжээ хариуцсан мэргэжилтэн/ |
| 4.3 | АТГ-аас санаачилсан аян, арга хэмжээг дэмжиж ажиллах, авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчилах /байгууллагын цахим хуудсанд/; | Жилдээ | АЭХ тогтоомжийг ажилчдад, олон нийтэд сурталчилсан байна. | ХНГЭЗХ /ЭБАТ, Хууль, эрх зүйн мэргэжилтэн, Мэдээлэл технологи, дотоод сүлжээ хариуцсан |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | мэргэжилтэн/ |
| 4.4 | АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг сургалт болон давтан сургалтуудад холбогдох албан тушаалтнуудыг хамруулах; | Жилдээ | Албан тушаалтан ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх ойлголт, мэдлэгтэй болно | ХНГЭЗХ /Хэлтсийн дарга, ЭБАТ/ |
| 4.5 | Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх; | Жилдээ | АТГ-аас ирүүлсэн зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд холбогдох шийдвэрүүдийг биелүүлж хариу мэдэгдсэн байна. | ХНГЭЗХ /Хэлтсийн дарга, ЭБАТ, Хууль, эрх зүйн мэргэжилтэн/ |
| 4.6 | Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд нэгдэх; | Жилдээ | Байгууллагын хүрээнд авлигатай тэмцэх эрмэлзэл, санаачилга өрнөсөн байна | Бүх хэлтэс, нэгж |
| 4.7 | Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар арга хэмжээ авах; | Жилдээ | Ашиг сонирхлын зөрчлөөс ангид болсон байна. | ХНГЭЗХ |
| **4 чиглэлээр** | | **Нийт 25 арга хэмжээ** | | |

ТАНИЛЦСАН: Судалгаа, хөгжил, сургалт хариуцсан дэд захирал Д.БАССАЙХАН

ХЯНАСАН: Хүний нөөц, гэрээ, эрх зүйн хэлтсийн дарга П.САНЛИГРЭНЧИН

БОЛОВСРУУЛСАН:

Хүний нөөц, гэрээ, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Л.МАЙЦЭЦЭГ

2022-01-25